ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/48/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273465 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....11
4. АУДИТЫН ТАЙЛАН....15
4.1 Ерөнхий зүйл....15
4.2 Материаллаг байдал....15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16
4.5.1 Завсрын аудитын талаар....16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/74
танай _____-ны № _____-т

БАЯН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА А.МӨНХ-ОД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газар нь "албан хаагчдын мэдлэг ур чадварыг тасралтгүй сайжруулж, мэргэжлийн, чадварлаг, бүтээлч, шинийг санаачлагч хамт олны хүчээр, төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ" гэсэн зорилтыг хэрэгжүүлэн, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг 91 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Тайлант онд цалин урамшуулал, хөрөнгө оруулалтын зардлаас хэмнэгдэж, зарцуулагдаагүй 230,512.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**66,826,939.80**	**161,395,433.60**
33	**АВЛАГА**	**0**	**78,635,000.00**
33500	**Бусад авлага**	**0**	**78,635,000.00**
33510	Байгууллагаас авах авлага	0	78,635,000.00
35	**БАРАА МАТЕРИАЛ**	**66,826,939.80**	**82,760,433.60**
35100	**Түүхий эд материал**	**4,293,261.80**	**3,787,161.80**
35110	Тусгай зориулалттай материал	2,051,461.80	2,051,461.80
35130	Эм боох материал	2,241,800.00	1,735,700.00
35400	**Хангамжийн материал**	**55,543,678.00**	**67,903,271.80**
35410	Бичиг хэргийн материал	2,228,080.00	1,792,320.00
35420	Аж ахуйн материал	29,307,298.00	49,334,951.80
35430	Сэлбэг хэрэгсэл	1,376,300.00	970,000.00
35470	Бусад хангамжийн материал	22,632,000.00	15,806,000.00
35600	Мал амьтад	6,990,000.00	11,070,000.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**2,150,621,732.47**	**2,551,476,506.62**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	**2,150,621,732.47**	**2,551,476,506.62**
39200	**Биет хөрөнгө**	**1,447,065,732.55**	**1,849,389,006.70**
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,689,255,204.77	2,793,742,809.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,604,127,201.57	-1,668,689,397.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	230,075,998.00	230,075,998.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-167,570,556.47	-190,296,036.35
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	86,720,613.00	112,676,885.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,845,938.85	-50,176,739.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,917,086.00	43,963,033.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,720,200.06	-25,745,497.65
39214	Бусад үндсэн хөрөнгө	495,745,238.33	434,858,497.73
39215	Хуримтлагдсан элэгдэл	-235,802,010.60	-128,559,894.86
39216	Дуусаагүй барилга, байгууламж	7,417,500.00	297,539,348.00
39300	**Биет бус хөрөнгө**	**703,555,999.92**	**702,087,499.92**
39301	Програм хангамж	8,007,500.00	7,342,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,909,500.08	-4,713,000.08
39303	Бусад биет бус хөрөнгө	699,458,000.00	699,458,000.00
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**2,217,448,672.27**	**2,712,871,940.22**
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**2,217,448,672.27**	**2,712,871,940.22**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	**2,217,448,672.27**	**2,712,871,940.22**
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,262,355,725.35	1,262,355,725.35
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,262,355,725.35	1,262,355,725.35
51200	**Хуримтлагдсан үр дүн**	**-7,325,566.68**	**488,924,763.76**
51210	Өмнөх үеийн үр дүн	32,559,956.03	-6,498,504.19
51220	Тайлант үеийн үр дүн	-39,885,522.71	495,423,267.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	962,418,513.60	961,591,451.11
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**2,217,448,672.27**	**2,712,871,940.22**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**623,503,408.19**	**1,401,440,229.18**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**113,861,348.00**	**133,309,618.03**
120	**Нийтлэг татварын бус орлого**	**113,861,348.00**	**133,309,618.03**
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	104,845,748.00	127,087,618.03
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,015,600.00	6,222,000.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**509,642,060.19**	**1,268,130,611.15**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**70,620,795.19**	**60,870,311.15**
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,935,530.90	5,693,837.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,685,264.29	55,176,474.15
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	**439,021,265.00**	**1,207,260,300.00**
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	439,021,265.00	1,207,260,300.00
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**663,071,743.41**	**905,947,482.02**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**663,071,743.41**	**782,328,582.02**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**509,931,253.41**	**513,042,680.29**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**204,358,240.76**	**182,193,352.76**
210101	Үндсэн цалин	127,301,636.28	146,918,395.08
210102	Нэмэгдэл	38,183,189.86	27,512,197.08
210104	Урамшуулал	0	7,762,760.60
210105	Гэрээт ажлын хөлс	38,873,414.62	0
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**26,574,576.66**	**22,344,832.36**
210201	Тэтгэврийн даатгал	18,745,224.88	15,479,722.33
210202	Тэтгэмжийн даатгал	2,081,411.38	1,821,143.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,651,688.99	1,456,915.16
210204	Ажилгүйдлийн даатгал	370,660.46	323,719.29
210205	Эрүүл мэндийн даатгал	3,725,590.95	3,263,331.85
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**50,187,997.64**	**50,130,699.88**
210301	Гэрэл, цахилгаан	5,728,797.00	5,671,495.00
210302	Түлш, халаалт	44,459,200.64	44,459,204.88
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**21,741,339.63**	**26,845,010.00**
210401	Бичиг хэрэг	2,485,069.63	2,508,260.00
210402	Тээвэр, шатахуун	12,039,940.00	11,534,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	680,100.00	636,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,010,350.00	11,930,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	525,880.00	235,200.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**425,500.00**	**508,400.00**
210604	Урсгал засвар	425,500.00	508,400.00
2107	**Томилолт, зочны зардал**	**670,000.00**	**2,264,000.00**
210702	Дотоод албан томилолт	670,000.00	2,264,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**2,735,912.50**	**32,618,389.44**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	990,304.50	28,986,931.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	129,208.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486,800.00	486,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	240,000.00	239,658.00
210807	Газрын төлбөр	284,800.00	2,300,200.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**203,237,686.22**	**196,137,995.85**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,347,881.50	52,696,055.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	141,785,804.72	143,441,939.87
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**153,140,490.00**	**269,285,901.73**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**58,038,664.00**	**11,746,786.00**
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,758,664.00	10,746,786.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,280,000.00	1,000,000.00
2134	**Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт**	**95,101,826.00**	**257,539,115.73**
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,101,826.00	257,539,115.73
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**0**	**123,618,900.00**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	**0**	**123,618,900.00**
221001	Их засвар	0	123,618,900.00
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**	**-39,568,335.22**	**495,492,747.16**
V	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**	**317,187.49**	**69,479.21**
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	317,187.49	69,479.21
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	**-39,885,522.71**	**495,423,267.95**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	**509,642,060.19**	**1,268,130,611.15**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**0**	**821,827,100.00**
120	**Нийтлэг татварын бус орлого**	**0**	**821,827,100.00**
120004	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	**0**	**821,827,100.00**
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	0	821,827,100.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**509,642,060.19**	**446,303,511.15**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**70,620,795.19**	**60,870,311.15**
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	32,935,530.90	5,693,837.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	37,685,264.29	55,176,474.15
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	**439,021,265.00**	**385,433,200.00**
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	439,021,265.00	385,433,200.00
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**508,142,060.19**	**639,506,898.15**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**508,142,060.19**	**639,506,898.15**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**355,001,570.19**	**370,220,996.42**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**204,358,240.76**	**182,193,352.76**
210101	Үндсэн цалин	127,301,636.28	146,918,395.08
210102	Нэмэгдэл	38,183,189.86	27,512,197.08
210104	Урамшуулал	0	7,762,760.60
210105	Гэрээт ажлын хөлс	38,873,414.62	0
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**26,574,576.66**	**22,344,832.36**
210201	Тэтгэврийн даатгал	18,745,224.88	15,510,991.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,081,411.38	1,813,101.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,651,688.99	1,450,661.28
210204	Ажилгүйдлийн даатгал	370,660.46	321,930.85
210205	Эрүүл мэндийн даатгал	3,725,590.95	3,248,147.22
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**50,187,997.64**	**50,130,699.88**
210301	Гэрэл, цахилгаан	5,728,797.00	5,671,495.00
210302	Түлш, халаалт	44,459,200.64	44,459,204.88
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**18,275,149.63**	**25,412,750.00**
210401	Бичиг хэрэг	2,148,409.63	2,043,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,196,290.00	10,241,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	680,100.00	636,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,650,350.00	12,491,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	0
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**1,500,000.00**	**1,000,000.00**
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,000,000.00
2107	**Томилолт, зочны зардал**	**670,000.00**	**2,264,000.00**
210702	Дотоод албан томилолт	670,000.00	2,264,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,**	**2,735,912.50**	**32,618,389.44**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	990,304.50	28,986,931.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	129,208.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486,800.00	486,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	240,000.00	239,658.00
210807	Газрын төлбөр	284,800.00	2,300,200.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**50,699,693.00**	**54,256,971.98**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,595,693.00	54,256,971.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	0
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**153,140,490.00**	**269,285,901.73**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**58,038,664.00**	**11,746,786.00**
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,758,664.00	10,746,786.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,280,000.00	1,000,000.00
2134	**Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох**	**95,101,826.00**	**257,539,115.73**
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,101,826.00	257,539,115.73
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	**1,500,000.00**	**628,623,713.00**
V	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**	**1,500,000.00**	**628,623,713.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**1,500,000.00**	**628,623,713.00**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	**1,500,000.00**	**628,623,713.00**
220001	Барилга байгууламж	0	30,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	0	9,383,300.80
223001	Бусад хөрөнгө	0	19,814,938.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,500,000.00	569,425,474.20
VI	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-**	**-1,500,000.00**	**-628,623,713.00**
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	**2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**1,262,355,725.35**	**962,419,522.75**	**32,558,946.88**	**2,257,334,194.98**
2	**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**	**0**	**0**	**1,009.15**	**1,009.15**
3	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**1,262,355,725.35**	**962,419,522.75**	**32,559,956.03**	**2,257,335,204.13**
4	**Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт**	**0**	**-1,009.15**	**0**	**-1,009.15**
9	**Тайлант үеийн үр дүн**	**0**	**0**	**-39,885,522.71**	**-39,885,522.71**
10	**2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**1,262,355,725.35**	**962,418,513.60**	**-7,325,566.68**	**2,217,448,672.27**
11	**2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	**1,262,355,725.35**	**962,418,513.60**	**-7,325,566.68**	**2,217,448,672.27**
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	827,062.49	827,062.49
13	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**1,262,355,725.35**	**962,418,513.60**	**-6,498,504.19**	**2,218,275,734.76**
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-827,062.49	0	-827,062.49
19	Тайлант үеийн үр дүн	0	0	495,423,267.95	495,423,267.95
20	**2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл**	**1,262,355,725.35**	**961,591,451.11**	**488,924,763.76**	**2,712,871,940.22**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**1,207,260,300.00**	**976,748,195.44**	**230,512,104.56**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**396,180,000.00**	**348,124,482.44**	**48,055,517.56**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**384,433,200.00**	**336,377,696.44**	**48,055,503.56**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**217,699,800.00**	**182,193,352.76**	**35,506,447.24**
210101	Үндсэн цалин	173,256,000.00	146,918,395.08	**26,337,604.92**
210102	Нэмэгдэл	44,443,800.00	27,512,197.08	**16,931,602.92**
210104	Урамшуулал	0	7,762,760.60	**-7,762,760.60**
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**29,217,800.00**	**22,344,832.36**	**6,872,967.64**
210201	Тэтгэврийн даатгал	20,510,000.00	15,510,991.60	**4,999,008.40**
210202	Тэтгэмжийн даатгал	2,177,000.00	1,813,101.41	**363,898.59**
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,741,500.00	1,450,661.28	**290,838.72**
210204	Ажилгүйдлийн даатгал	435,400.00	321,930.85	**113,469.15**
210205	Эрүүл мэндийн даатгал	4,353,900.00	3,248,147.22	**1,105,752.78**
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**51,525,400.00**	**50,130,699.88**	**1,394,700.12**
210301	Гэрэл, цахилгаан	7,066,100.00	5,671,495.00	**1,394,605.00**
210302	Түлш, халаалт	44,459,300.00	44,459,204.88	**95.12**
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**24,365,500.00**	**24,357,050.00**	**8,450.00**
210401	Бичиг хэрэг	1,250,000.00	2,043,500.00	**-793,500.00**
210402	Тээвэр, шатахуун	9,055,500.00	9,186,000.00	**-130,500.00**
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,560,000.00	636,000.00	**924,000.00**
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	12,500,000.00	12,491,550.00	**8,450.00**
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**1,000,000.00**	**1,000,000.00**	**0.00**
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	**0.00**
2107	**Томилолт, зочны зардал**	**2,272,400.00**	**2,264,000.00**	**8,400.00**
210702	Дотоод албан томилолт	2,272,400.00	2,264,000.00	**8,400.00**
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний**	**36,879,300.00**	**32,618,389.44**	**4,260,910.56**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	32,997,500.00	28,986,931.44	**4,010,568.56**
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00	**0.00**
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	0	**250,000.00**
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486,800.00	486,800.00	**0.00**
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	240,000.00	239,658.00	**342.00**
210807	Газрын төлбөр	2,300,200.00	2,300,200.00	**0.00**
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**21,473,000.00**	**21,469,372.00**	**3,628.00**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,473,000.00	21,469,372.00	**3,628.00**
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**11,746,800.00**	**11,746,786.00**	**14.00**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**11,746,800.00**	**11,746,786.00**	**14.00**
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,746,800.00	10,746,786.00	**14.00**
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	**0.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**811,080,300.00**	**628,623,713.00**	**182,456,587.00**
220001	Барилга байгууламж	457,546,200.00	327,539,348.00	**130,006,852.00**
221001	Их засвар	215,265,800.00	214,128,005.00	**1,137,795.00**
222001	Тоног төхөөрөмж	28,068,300.00	67,141,422.00	**-39,073,122.00**
223001	Бусад хөрөнгө	110,200,000.00	19,814,938.00	**90,385,062.00**
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**1,207,260,300.00**	**976,748,195.44**	**230,512,104.56**
32	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**385,433,200.00**	**337,377,682.44**	**48,055,517.56**
320001	Орон нутгийн төсвөөс	385,433,200.00	337,377,682.44	**48,055,517.56**
35	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	**821,827,100.00**	**639,370,513.00**	**182,456,587.00**
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	821,827,100.00	639,370,513.00	**182,456,587.00**

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**46,724,447.50**	**33,843,299.98**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**46,724,447.50**	**33,843,299.98**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	46,724,447.50	33,843,299.98
2104	**Хангамж, бараа материалын зардал**		1,055,700.00
210402	Тээвэр, шатахуун		1,055,700.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	990,304.50	01.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	990,304.50	01.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	45,734,143.00	32,787,600.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,630,143.00	32,787,599.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	01.00
II	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	46,724,447.50	33,843,299.98
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	46,724,447.50	33,843,299.98
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,314,327.50	5,672,214.98
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,410,120.00	28,171,085.00
IV	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)**		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газар нь сумын хэмжээнд төр засгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцох, Засаг даргын тамгын газрыг мэргэшсэн мэдлэг чадвар бүхий албан хаагчаар бэхжүүлэхэд зохион байгуулалтын болон мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, төрийн захиргааны шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд манлайлан оролцох замаар төрийн захиргааны ажлыг тогтвортой, чанартай шуурхай, стандартын дагуу явуулж, үр дүнд хүргэнэ гэсэн эрхэм зорилготой байна.

Баян сумын Засаг даргын тамгын газар нь “албан хаагчдын мэдлэг ур чадварыг тасралтгүй сайжруулж, мэргэжлийн, чадварлаг, бүтээлч, шинийг санаачлагч хамт олны хүчээр, төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлэн, сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилт, 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр байгуулан ажиллаж, гүйцэтгэлээр 91 хувиар биелсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баян сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн А/05 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус тушаалаар дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгосныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант хугацаанд дотоод хяналт шалгалтыг нэг удаа удирдамж боловсруулан зохион байгуулсан гэх боловч хяналт шалгалт хийх төлөвлөгөө гаргаж батлуулаагүй, хяналт шалгалт явуулсан тайлан нь хэтэрхий товч, зурагжуулсан нотлох баримт байхгүй байгаа нь хяналт шалгалт хийсэн гэж үзэх боломжгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2016 онд шинэчлэн боловсруулагдсан 8 хэсэг, 26 дэд хэсэгтэй байна. Төв аймгийн СТСХ-с нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нэгдсэн журмаар боловсруулж өгөх чиглэл өгсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 495,423.3 мянган төгрөгөөр буюу 22,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	0	78,635.0	78,635.0
Бараа материал	66,826.9	82,760.4	15,933.5
Үндсэн хөрөнгө	2,150,621.7	2,551,476.5	400,854.8
Нийт хөрөнгө	**2,217,448.6**	**2,712,871.9**	**495,423.3**
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	**2,217,448.6**	**2,712,871.9**	**495,423.3**
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**2,217,448.6**	**2,712,871.9**	**495,423.3**

Дээрх хүснэгтээс харахад авлага дансны үлдэгдэл 78,635.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь тайлант онд хийгдэж дуусаагүй 75,995.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг авлагаар бүртгэж тайлагнасан. Мөн Төв аймгаас хуваарилсан өвсийг татаж авч амжаагүй 2,640.0 мянган төгрөгийг авлага үүсгэн бүртгэсэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл оны эцэст 82,760.4 мянган төгрөг буюу өмнөх оноос 15,933.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд Засаг даргын тамгын газар, гудамж талбайг камержуулсны дагалдах хэрэгслийг аж ахуйн материал дансанд 10,838.9 мянган төгрөгөөр, жишиг гудамж, хуучин барилгын засвар, наадмын тохижилтын зураг төсвийн үнэ 9,500.0 мянган төгрөгийг орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 2,551,476.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 400,854.8 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн шилжих үлдэгдлээс батлагдсан хөрөнгө оруулалтын зардлаар ЗДТГ-ын 46,830.0 мянган төгрөгийн болон Цагдаагийн кабоны барилгын 43,679.1 мянган төгрөгийн засварыг сайжруулалтаар бүртгэсэн, сумын төв доторх 2 км-ын авто замыг 297,538.3 мянган төгрөгийг дуусаагүй барилга дансанд, тамгын газрын ажиллагсдын компьютер тоног төхөөрөмжийг шинэчилсэн 19,664.4 мянган төгрөг, камержуулах 28,446.5 мянган төгрөгийн ажлуудыг орлогоор бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус Засаг даргын тамгын газар нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн орлогоос 385,085.9 мянган төгрөг, нийт зарлагыг 385,085.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас тамгын газрын урсгал үйл ажиллагааны зардлаас 11,125.7 мянган төгрөгөөр бууруулан, сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 03 тоот тогтоолоор урсгал зардлыг 373,960.2 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зардлыг 821,827.1 мянган төгрөгөөр буюу нийт 1,195,787.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй өмнөх оны орон нутгийн шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 821,827.1 мянган төгрөг нэмж баталснаас шалтгаалсан байна.

Аймгийн СТСХ-с 2022 оны 12 дугаар сард төсвийн хэлбэлзэлд үндсэн үйл ажиллагааны бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулах эрхийг 11,473.0 мянган төгрөгөөр олгосноор батлагдсан төсвийг 1,207,260.3 мянган төгрөгөөр тооцсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй, сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор орон нутгийн шилжих үлдэгдлээр хийгдэх ажлын жагсаалтад өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,207,260.3 мянган төгрөгийг сумын татварын орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос урсгал зардалд 385,433.2 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 821,827.1 мянган төгрөг, нийт 1,207,260.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 976,748.2 мянган төгрөг буюу 80,9 хувьтай байгаа нь зарим арга хэмжээний зардлыг дутуу зарцуулж, тайлант оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 230,512.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101 үндсэн үйл ажиллагааны зардал	270,772.3	229,482.9	41,289.4	84,7
2	70106-80103 гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	52,280.4	47,182.0	5,098.4	90,2
3	70106-80106 баг хорооны үйл ажиллагааны зардал	38,880.5	3,7222.6	1,657.9	95,7
4	70106-80802 ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	11,746.8	11,746.8	0	100
5	70106-80918 бусад	811,080.3	628,623.7	182,456.6	77,5
6	70106-81102 орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	4,998.6	1.4	99,9
7	70106-82801 улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100
8	71411-82212 хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	12,500.0	12,491.6	8,4	99,9
		1,207,260.3	976,748.2	230,512.1	80,9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд цахим тендерийн хураамж 875.0 мянган төгрөг, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардал 1,059.5 мянган төгрөг, Засгийн газраас төлсөн усны үнэ 286.9 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажил зуучлалын зардал 81.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс ХАА-н ээлжит тооллого явуулах зардал 3,106.4 мянган төгрөг, хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгааны зардал 120.0 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлогын 29,500.0 мянган төгрөг, Төв ОНХС-с спорт чийрэгжүүлэлтийн тоглоомын талбай байгуулах ажлын барьцаа 1,040.0 мянган төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын барьцаа хөрөнгө 13,058.5 мянган төгрөг, өвс, тэжээлийн үнэ 11,743.0 мянган төгрөг нийт 60,870.3 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Нэмэлтийн харилцах данснаас сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний урьдчилгаа санхүүжилтэд 20,000.0 мянган төгрөг, зураг төсвийн үнэ 9,500.0 мянган төгрөг, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шатахууны зардалд 1,055.7 мянган төгрөг, ажил зуучлалын зардалд 79.1 мянган төгрөг, ХАА-н ээлжит тооллого явуулах зардалд 3,088.6 мянган төгрөг, хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгааны зардалд 120.0 мянган төгрөг, нийт 33,843.4 мянган төгрөгийн зардал гарсан.

Баян сумын ЗДТГ нь нэмэлт данснаас зарцуулсан үлдэгдэл өвсний үнэ 11,743.0 мянган төгрөг, ЗГ-ын усны мөнгө 286.9 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 875.0 мянган төгрөг, спорт чийрэгжүүлэлтийн тоглоомын талбай байгуулах ажлын захиалагчийн хяналт 1,040.0 мянган төгрөг, сумын ЗДТГ-с хөрөнгө оруулалтын ажлын барьцаа хөрөнгө 13,058.5 мянган төгрөг буюу нийт 27,027.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022	Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.	84,8	1,194,760.3	964,256.6
2	71411 хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022	Хог хаягдлын хураамжийн төлөвлөгөөг 100% ханган биелүүлж, хог хаягдлыг тогтмол цэвэрлэн хур хог хаягдал үүсгэлгүй ажиллана	2022 онд 12,986.5 мянган төгрөгийн хог хаягдлын хураамжийн орлого төвлөрүүлсэн.	12,500.0	12,491.6
			Дүн		1,207,260.3	976,748.2

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 1,195,787.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 17,936.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,452.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд цалин урамшууллын зардлыг орон тоо дутуу ажилласнаас, хөрөнгө оруулалтын зарим төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжээгүйгээс хэмнэгдсэн, 230,512.1 мянган төгрөгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баян сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 163,860.3 мянган төгрөгийн 2 орлогын, 29,500.0 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг болон төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 262,159.9 мянган төгрөгийн 12 шийдвэрийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баян сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж, аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ирүүлсэн.

Завсрын аудитаар өгөгдсөн нэмэлтийн харилцах дансанд 2021 онд Засгийн газраас олгосон усны төлбөрийн үлдэгдэл 286.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг аудитын тайланд тусгахаар шийдвэрлэв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг ЗДТГ-ын 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр 03/23 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	6,990.0	2	6,990.0	100
Нийт дүн	2	6,990.0	2	6,990.0	**100**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баян сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар орон нутгийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт гүйцэтгэлд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 243,927.6 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 243,927.6 мянган төгрөгийн алдааг залруулав.

1.Мөнгөн гүйлгээний тайлан дахь хөрөнгийн зардал орон нутгийн шилжих үлдэгдлээс улсын төсвийн байгууллагуудад хийгдсэн хөрөнгө оруулалтаас шалтгаалан, үндсэн хөрөнгийн тайлангийн тодруулгаас 203,927.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д ”үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2.Сумын төв доторх 2 км замын зураг төсвийн үнэ 40,000.0 мянган төгрөгийг аж ахуйн материал дансанд орлогоор бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д ”үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 463,613.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 286.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 7,806.0 мянган төгрөгийн албан шаардлага, 455,520.2 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн.

5.2 Төлбөрийн акт

1.Завсрын аудитаар 2021 онд Засгийн газраас чөлөөлсөн усны төлбөр 286.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д ”үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 23 дугаар зүйлийн 23.6-д “Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

Бараа материалын үлдэгдлийг тулгахад бичиг хэргийн материал дансанд 360.0 мянган төгрөгийн 20 боодол бичгийн цаас, 566.0 мянган төгрөгийн 17ш принтерийн хорны, бусад хангамжийн материал дансанд 1,880.0 мянган төгрөгийн үнэтэй 47ш улиас, 5,000.0 мянган төгрөгийн үнэтэй 1000ш шар хуайс, үлдэгдэлтэй байна.
Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага бичив.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

Баян сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 163,860.3 мянган төгрөгийн 2 орлогын, 29,500.0 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг болон төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 262,159.9 мянган төгрөгийн 12 шийдвэрийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардал зөрүүтэй	1	203,927.6			1	203,927.6	1	203,927.6				
Зураг төсвийн үнийг материалд бүртгэсэн	1	40,000.0			1	40,000.0	1	40,000.0				
Дүн	2	243,927.6			2	243,927.6	2	243,927.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлого дутуу төв-сэн	1	286.9	1	286.9								
Бараа материалын үлдэгдэл	1	7,806.0			1	7,806.0						
Дүн	2	8,092.9	1	286.9	1	7,806.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	1	455,520.2					1	455,520.2
Дүн	1	455,520.2					1	455,520.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	455,520.2					1	455,520.2